



I-XII/2021


Тархаасан: 2022 оны 1 дүгээр сарын 12



Экспорт өмнөх сараас 68.1 хувиар буурлаа

Монгол Улс 2021 онд нийт 159 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 16.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 9.2 тэрбум америк доллар, импорт 6.8 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 3.2 (25.0%) тэрбум америк доллароор, экспорт 1.7 (22.1%) тэрбум америк доллароор, импорт 1.5 (29.2%) тэрбум америк доллароор тус тус өсжээ. Харин 2021 оны 12 дугаар сард экспорт 417.3 сая америк доллар, импорт 660.7 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 889.0 (68.1%) сая америк доллароор буурсан бол импорт 117.9 (21.7%) сая америк доллароор өссөн байна.

ЗУРАГ 1. ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ, сараар, сая америк доллароор



Гадаад худалдааны тэнцэл 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.4 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оноос 121.1 (5.3%) сая америк доллароор өсжээ. Харин гадаад худалдааны тэнцэл 2021 оны 12 дугаар сард 243.4 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх сараас 1.0 тэрбум америк доллароор буурсан байна.

БНХАУ-тай 2021 онд 10.2 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 63.1 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ЭКСПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эцсийн байдлаар

Улс орон	2019		2020		2021*		БНХАУ-д экспортолсон бараа бүтээгдэхүүний 32.3 хувийг чулуун нүүрс, 38.0 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 98.0 хувийг, БНСУ-д экспортолсон барааны 68.2 хувийг алт эзэлж байна.
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	
Дүн	7 619.6	100.0	7 576.3	100.0	9 247.1	100.0	
БНХАУ	6 789.7	89.1	5 493.6	72.5	7 643.9	82.7	
Швейцар	75.0	1.0	1 681.6	22.2	869.7	9.4	
Сингапур	154.5	2.0	151.3	2.0	254.7	2.8	
БНСУ	27.8	0.4	21.4	0.3	223.4	2.4	
ОХУ	68.1	0.9	57.3	0.8	112.8	1.2	
Бусад	504.5	6.6	171.2	2.3	142.6	1.5	


Экспорт 2021 онд өмнөх оноос 1.7 тэрбум америк доллароор өсөхөд зэсийн баяжмалын экспорт 1.1 тэрбум америк доллар, нүүрсний экспорт 652.9 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 2. УУЛ УУРХАЙН ГАРАЛТАЙ ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, жил бүрийн эцсийн байдлаар, сая америк доллароор

Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		2021*	Үнийн дүн		2021*
		2020	2021*	2020	2020	2021*	2020
Зэсийн баяжмал	мян.т	1 395.1	1 282.5	91.9	1 778.0	2 899.9	163.1
Нүүрс	сая.т	28.7	16.1	56.3	2 126.6	2 779.5	130.7
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	т	30.5	17.2	56.6	1 787.7	1 004.5	56.2
Төмрийн хүдэр, баяжмал	мян.т	8 205.7	7 106.2	86.6	640.0	952.2	148.8
Боловсруулаагүй газрын тос	мян.барр	4 070.5	4 348.9	106.8	150.9	273.4	181.2


Мөн уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ өссөнтэй холбоотойгоор экспортын орлого нэмэгдэж байна. Тухайлбал, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ өмнөх оноос 8.1 хувиар буурсан бол үнийн дүн 63.1 хувиар өсжээ.

ЗУРАГ 2. ЭКСПОРТЫН ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, ам.доллаароор



Экспорт 2021 оны 12 дугаар сард өмнөх сараас 889.0 сая америк доллароор буурахад нүүрсний экспорт 460.2 сая америк доллароор, алтны экспорт 217.2 сая америк доллароор буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

ЗУРАГ 3. НҮҮРСНИЙ ЭКСПОРТ, 2021 он, сараар



2021 оны импортын дүнг авч үзвэл, БНХАУ 36.8%, ОХУ 28.6%, Япон Улс 6.6%, БНСУ 4.5%, ХБНГУ 3.3%, АНУ 3.1 хувийг тус тус эзэлж, нийт импортын 82.9 хувийг бүрдүүлж байна.


ХҮСНЭГТ 3. ИМПОРТ, гол түнш улсаар, жил бүрийн эцсийн байдлаар

Улс орон	2019		2020		2021*	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	6 127.5	100.0	5 298.9	100.0	6 848.6	100.0
БНХАУ	2 060.8	33.6	1 910.3	36.1	2 520.0	36.8
ОХУ	1 729.9	28.2	1 400.0	26.4	1 960.6	28.6
Япон	585.5	9.6	406.7	7.7	453.1	6.6
БНСУ	267.0	4.4	235.8	4.4	308.7	4.5
ХБНГУ	188.9	3.1	184.8	3.5	223.2	3.3
АНУ	289.6	4.7	245.4	4.6	213.2	3.1
Бусад	1 005.9	16.4	916.1	17.3	1 169.8	17.1

ОХУ-аас импортоор оруулсан барааны 51.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 70.4 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 5.0 хувийг цахилгаан эрчим хүч, 11.3 хувийг ачааны тэрэг, 83.7 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Импорт өмнөх оноос 1.5 тэрбум америк доллароор өсөхөд дизелийн түлшний импорт 157.7 сая америк доллароор, автобензин 146.4 сая америк доллароор, ачааны автомашин 116.2 сая америк доллароор, суудлын автомашины импорт 87.8 сая америк доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 4. ИМПОРТЫН ӨӨРЧЛӨЛТ, бүтээгдэхүүнээр, сая америк доллароор, 2021 он, урьдчилсан гүйцэтгэлээр



Эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл, гоёлын зүйлс болон нэхмэл бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 96.4 хувийг эзэлж байгаа бол импортын 64.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. ЭКСПОРТ, ИМПОРТ, зарим барааны бүлгээр, жил бүрийн эцсийн байдлаар

Үзүүлэлт	2019	2020	2021*	<u>2021*</u> 2020
	сая ам.доллар			хувь
Экспорт	7 619.6	7 576.3	9 247.1	122.1
Эрдэс бүтээгдэхүүн	6 377.6	5 256.0	7 516.0	143.0
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	61.9	70.2	47.1	67.1
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	12.5	11.0	89.3	8.1 ¹
Нэхмэл бүтээгдэхүүн	434.7	279.5	370.7	132.6
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	419.1	1 789.9	1 025.4	57.3
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	418.4	1 787.7	1 004.5	56.2
Импорт	6 127.5	5 298.9	6 848.6	129.2
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	444.3	434.4	607.2	139.8
Эрдэс бүтээгдэхүүн	1 372.3	1 007.2	1 338.6	132.9
Автобензин	327.4	244.7	391.1	159.8
Дизелийн түлш	669.4	432.4	590.1	136.5
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	541.9	535.7	567.2	105.9
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги	1 163.7	849.8	1 228.4	144.5
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	365.9	370.8	587.4	158.4
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	260.3	223.1	252.1	113.0
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	1 240.7	1 060.6	1 248.7	117.7

¹ - Дахин их

Ойлголт, тодорхойлолт

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Реэкспорт: Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Эх орны үйлдвэрлэлийн бараа: Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.



Эх үүсвэр:

Гаалийн Ерөнхий Газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 2 дугаар сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын дарга
А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212